



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРОО**

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон  
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2012. 05. 03 № 11/313P

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНД**

Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2012 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг хүргүүллээ. Хэрэгжилтийг зохион байгуулна уу.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА  Р.БУД



0000132



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛ

2012 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Хэлэлцсэн нь:** Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны үйл ажиллагааны тайлан

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороонд дараах асуудлаар чиглэл өгөх нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1. 2006 онд болсон Хадгаламж, зээлийн хоршоодын хямралын үеэр дампуурсан хоршоодын төлбөр барагдуулалтын талаар хохирогчдын төлөөллөөс гаргаж байгаа гомдол, шүүмжлэлийг шалган тодруулах, тэднээс хохирлын үлдсэн хэсгийг төрөөс нөхөн олгох хүсэлтийг судлан шийдвэрлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, асуудлыг нэг мөр болгосон хариултыг олон нийтэд мэдээлэх,

2. Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд стратегийн ач холбогдол бүхий орд газруудын хувьцааны 10-аас доошгүй хувийг дотоодын хөрөнгийн биржээр арилжаалах, "Эрдэнэс МГЛ" ХК болон "Эрдэнэс Таван толгой" ХХК-ийн хувьцааны тодорхой хэсгийг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжүүдэд худалдаалах, гадаад, дотоодын хөрөнгийн зах зээл дээр арилжаалах бэлтгэл ажлыг хангах болон уг арга хэмжээг зохион байгуулахад Санхүүгийн зохицуулах хорооны оролцоог идэвхжүүлэх,

3. Арилжааны даатгалын зах зээл идэвхтэй бус байгаад онцгой анхаарч, даатгалд хамрагдаагүй байгаа үндсэн хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийг даатгалын зах зээлийн эргэлтэд бүрэн хамруулах, үндсэн хөрөнгийг бүртгэлжүүлэх, дахин үнэлэх асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах,

4. Монголын Хөрөнгийн биржийн шинэчлэлийг хурдавчлах, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг бүрдүүлж, тэнд ажил, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын санхүүгийн болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх, тэдгээрийн ажиллагаанд тавих хяналтыг өргөтгөж чанаржуулах арга хэмжээ авах, Санхүүгийн зохицуулах хорооноос иргэд, олон нийт, санхүүгийн болон хөрөнгийн зах зээлд оролцогчдоос тавьсан санал, гомдлыг хянан шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулж байхад анхаарч ажиллах,

5. Компанийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Зээлийн батлан даалтын тухай хууль зэрэг санхүү,

хөрөнгийн зах зээлд нийтлэг үйлчлэх шинэ хуулиудын хэрэгжилтийг сайтар зохион байгуулж, сурталчлах, компанийн засаглалыг боловсронгуй болгох чиглэлээр дорвитой арга хэмжээ авах,

6. 2012 оны төсөвт тусгагдаагүй үлдсэн хөрөнгө оруулалтын зардал, тухайлбал хорооны албан байрны багтаамжийг нэмэгдүүлэх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төвийн барилга, тоног төхөөрөмж, санхүүгийн мэдээллийн технологийн шинэчлэл, хүний нөөцийн хангалт, сургалт, дадлагажилтад шаардагдах хөрөнгийн тооцоо судалгааг нарийвчлан гаргаж 2012 оны төсвийн тодотголд болон 2013 оны төсөвт тусгуулах саналаа Засгийн газар, Улсын Их Хуралд ирүүлж шийдвэрлүүлэх, энэ талаар гадаад улсуудын ижил төрлийн байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах,

7. Санхүүгийн зохицуулах хорооны зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгохтой холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх, үүргийг өргөтгөх, бие даасан байдлыг хангах, орон нутагт төлөөлөлтэй болох асуудлыг судлан боловсруулж, шаардлагатай бол холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Р.БУД

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.УУГАНЦЭЦЭГ